

Referral to School Counsellor/School Psychologist

From Learning and Support Team

Сургуулийн Сэтгэлзүйч/Сургуулийн Сэтгэл судлаачтай уулзах илгээх бичиг
Сургалтын болон Дэмжлэг Үзүүлэх Багаас

Мэдээллийн нууцлалыг хадгалах журам: Энэхүү мэдээллийг сургуулийн сэтгэлзүйн зөвлөгөө өгөх ажилтан таны хүүхдэд дэмжлэг үзүүлэхэд туслах зорилгоор авч байгаа юм. Энэхүү мэдээллийг өгөх эсэх нь таны сайн дурын шийдвэр байх бөгөөд таны өгөх мэдээлэл найдвартай хадгалагдах болно. Шаардлагатай гэж үзсэн тохолдолд таны олгосон мэдээлэл болон хийсэн үнэлгээний үр дүнг уг ажилтан нь сургуулийн бусад ажилтнуудтай хуваалцах боломжтой. Та хэдийд ч сургуулийн сэтгэлзүйч ажилтантай холбогдон өгсөн хувийн мэдээллээ өөрчлөх, залруулах боломжтой.

Хэрвээ танд энэхүү анкетийг бөглөхөд тусламж хэрэгтэй бол сургуультай холбогдоно уу. Хэрвээ сургуультай холбогдоход тань орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн хэл дээрх орчуулагчийг хүсээрэй. Операторт залгахыг хүссэн дугаараа хэлэхэд оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Энэ үйлчилгээ нь үнэ төлбөргүй юм.

Name of student	Сурагчийн нэр
Name of school	Сургуулийн нэр
Date of birth	Төрсөн он сар өдөр
Date of referral	Илгээх бичгийн он сар өдөр

Эцэг эх эсвэл асран хамгаалагч доорх мэдээллийг Англи хэл дээр бөглөнө – хэрвээ зайнд багтахгүй бол хуудас нэмж оруулна уу.

Илгээх бичгийн шалтгаан/эцэг эхийн санаа зовнисон асуудал Reason for referral/parent's concerns

Хүүхдийн хөгжил/эрүүл мэндийн түүх Developmental/medical history
Тухайлбал, та хүүхдийнхээ хэл, яриа, эсвэл булчингийн хөгжилд санаа зовниж байсан уу? Таны хүүхдэд ямар нэгэн ноцтой эмгэг байгаа юу?

Өмнөх үнэлгээнүүд Previous assessments
Тухайлбал эмчийн, сэтгэл судлаач болон хэл яриа засалчийн хийсэн үнэлгээ (Үнэлгээг хэн хийснийг дурдах ба боломжтой бол үнэлгээний тайланг хавсаргана уу.)

Дэлгэрэнгүй мэдээлэл More information
Танд сургуулийн сэтгэлзүйч эсвэл/сургуулийн сэтгэл судлаачид мэдэгдэхийг хүсч буй нэмэлт мэдээлэл байгаа юу?

Таны хүүхэд сургуулийн сэтгэлзүйч /сургуулийн сэтгэл судлаачтай уулзсанаар ямар үр дүн гарна гэж та найдаж байгаа вэ?
What do you hope will happen as a result of the school counsellor/school psychologist seeing your child?

Би Мэдээллийн нууцлалыг хадгалах журамтай уншиж танилцсан ба сургуулийн сэтгэлзүйч /сургуулийн сэтгэл судлаачид дараах зөвшөөрлийг олгож байна. Үүнд:

Үнэлгээ хийх, мөн шаардлагатай сэтгэлзүйн зөвлөгөөг өгөх Carry out assessment and counselling as required	Тийм Yes	Үгүй No	
Миний өгсөн үнэлгээний тайланг гаргасан хүнтэй холбогдох Contact the authors of the reports I have provided	Тийм Yes	Үгүй No	Тайланг гаргасан байгууллага Reports from
Эдгээр байгууллагуудтай мэдээлэл солилцох Exchange information with these agencies	Тийм Yes	Үгүй No	

Эцэг эх/асран хамгаалагчийн гарын үсэг
Signature of parent/carer

Он сар өдөр
Date